



**Арилжааны мэдээ**

- Монголын хөрөнгийн бирж 2019 оны 6 дугаар сарын 24-ны өдрөөс 2019 оны 6 дугаар сарын 28-ны өдрүүдэд 5 удаагийн үнэт цаасны арилжааг зохион байгуулж, өдөрт дунджаар 223 сая төгрөг буюу нийт 1,117,580,151.33 төгрөгийн арилжаа хийсэн байна.
- 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,601,660,661,176.60 төгрөг болсон бол “ТОП 20” индекс 20785.21 нэгж болж өмнөх долоо хоногоос 5.26% хувиар өссөн үзүүлэлттэй байна.

**MSE Top 20 индекс**

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

**Монгол банкны USD/MNT ерөнхий харьцаа**

Эх сурвалж: Монгол Банк

**Зах зээлийн өөрчлөлт**

| Индекс            | Нэгж     | % Өөрчлөлт |
|-------------------|----------|------------|
| MSE Top-20 индекс | 19746.62 | 5.26%      |
| MSE A индекс      | 9743.03  | 10.65%     |
| MSE B индекс      | 8116.71  | 1.58%      |

| Зах зээлийн хураангуй | Нийт (MNT)           |
|-----------------------|----------------------|
| Зах зээлийн үнэлгээ   | 2,601,660,661,176.60 |
| Арилжигдсан үнийн дүн | 1,117 сая төгрөг     |

| Үнийн дүнгээр      | Хаалт (MNT) | Мөнгөн дүн     |
|--------------------|-------------|----------------|
| АРД ДААТГАЛ ХК     | 769.35      | 321,118,461.07 |
| АРД КРЕДИТ ББСБ ХК | 81.83       | 254,684,093.23 |
| МОНГОЛ ШУУДАН ХК   | 691.16      | 109,194,897.00 |
| МОНОС ХҮНС         | 71.10       | 62,431,932.98  |
| ТҮМЭН ШУВУУТ       | 185.63      | 60,784,539.24  |

| Тоо ширхэгээр      | Хаалт (MNT) | Нийт         |
|--------------------|-------------|--------------|
| АРД КРЕДИТ ББСБ ХК | 81.83       | 6,006,668.00 |
| МОНОС ХҮНС         | 71.10       | 880,703.00   |
| ЛЭНДМН ББСБ ХК     | 64.97       | 873,358.00   |
| АРД ДААТГАЛ ХК     | 769.35      | 463,783.00   |
| ТҮМЭН ШУВУУТ       | 185.63      | 323,447.00   |

| Ханш өссөн        | Хаалт (MNT) | % Өөрчлөлт |
|-------------------|-------------|------------|
| МИК ХОЛДИНГ       | 14500       | 36.79      |
| Э-ТРАНС ЛОЖИСТИКС | 132.25      | 32.25      |
| ХҮННҮ МЕНЕЖМЕНТ   | 281.35      | 32.24      |
| ШИВЭЭ ОВОО        | 2104        | 23.69      |
| МОНГОЛ ШУУДАН ХК  | 691.16      | 15.58      |

| Ханш буурсан  | Хаалт (MNT) | % Өөрчлөлт |
|---------------|-------------|------------|
| НИЙСЛЭЛ ӨРГӨӨ | 5015        | -15.00     |
| СИЛИКАТ       | 132.25      | -14.29     |
| АРИГ ГАЛ      | 3200        | -11.11     |
| РЕМИКОН       | 27          | -9.70      |
| МОГОЙН ГОЛ    | 6600        | -5.71      |

**Тодруулга**

Энэхүү арилжааны мэдээ нь зөвхөн арилжааны болон санхүүгийн мэдээлэл өгөх зорилготой бөгөөд аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Энэхүү мэдээнд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “БиДиСек ҮЦК” ХК хариуцлага хүлээхгүй болно.



**ЭНЭ ДОЛОО ХОНОГТ**

**“ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН” ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ҮР ДҮНГ ТАНИЛЦУУЛАА. (mse.mn)**

“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” (TSX:ERD | MSE:ERDN) нь 2019 оны 6-р сарын 20-нд Нова Скошиа мужийн Халифакс хотод зохион байгуулагдсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үр дүнг танилцуулсан байна. Хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгох, аудиторыг дахин томилох, хуваарилагдаагүй опционыг батлах, ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн хөтөлбөрт өөрчлөлт оруулах зэрэг асуудлуудыг хэлэлцэн баталсан байна.

Хэвлэлийн мэдээний дэлгэрэнгүйг **Энд** дарж үзнэ үү.

**АЛТНЫ СПОТ ХАНШ 1439 АМ.ДОЛЛАР ХҮРТЭЛ ӨСӨЖ, СҮҮЛИЙН 6 ЖИЛИЙН ДЭЭД ТҮВШИНД ХҮРЛЭЭ. (bloombergtv.mn)**

Алтны ханш өнгөрсөн долоо хоногт өсөж, 1400 ам.доллар давсан бол энэ долоо хоногт ч мөн өсөлт үргэлжилж, спот ханш 1439 ам.доллар буюу сүүлийн зургаан жилийн дээд цэгт хүрээд байна.

АНУ Ираны эсрэг шинэ хориг арга хэмжээ авахаар зэхэж эхэлсэн нь дэлхийн эдийн засаг дахь тодорхойгүй байдлыг нэмэгдүүлж байна гэж шинжээчид үзэж байна. Улмаар хөрөнгө оруулагчид эрсдэл өндөртэй шийдвэрээс зайлсхийж алтыг сонгох нь нэмэгдэж байгаа юм. Үүний зэрэгцээ 2019 оны үлдсэн хугацаанд үнэт металл алтны ханш үргэлжлэн өсөх төлөвтэй гэсэн таамгийг томоохон банк санхүүгийн байгууллагууд дэвшүүлж байна. Тухайлбал, “Morgan Stanley” өмнөх таамгийнхаа дүнг ахиулж, энэ оны II хагаст алт дунджаар 1435 ам.доллараар арилжаалагдана гэж тооцоолоод байна. Харин ирэх 2020 онд 1338 ам.долларын дундаж ханштай байна гэж урьдчилан таамаглаж байгаа юм.

“Citigroup”-ийн тухайд үүнээс илүү өндөр дүнтэй таамгийг дэвшүүлж байна. Өөрөөр хэлбэл ойрын 12 сарын хугацаанд алтны ханш дээд тал нь 1500-1600 ам.доллар хүрч өсөж магадгүй гэж үзжээ. Австралид төвтэй хөрөнгө оруулалтын банк “Macquarie Wealth Management” ханшийг ирэх 2020 оны I эсвэл II улирал хүртэл 1450 ам.долларт хэлбэлзэнэ гэж таамагласан байна.

Олон улсын хэмжээнд геополитикийн маргаантай асуудлууд хурцдаж, улмаар тэр нь эдийн засгийн хэтийн төлөвт тодорхойгүй байдал үүсгэхийн хэрээр хөрөнгө оруулагчид илүү найдвартай хэрэгслийг сонгох нь ихсэж байна. Үүний нэг баталгааг зургаадугаар сар гарснаас хойш алттай холбоотой арилжааны сангуудад гурван тэрбум ам.долларын хөрөнгийн урсгал орж ирснээс харж болохоор байгаа ажээ. Энэ нь сүүлийн таван сарын хугацааны дээд дүн болоод байгаа юм.

**“МОНГОЛ БАЗАЛТ” ХК 2018 ОНЫ НОГДОЛ АШГИЙГ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ДАНСАНД БАЙРШУУЛАА.(schcd.mn)**

Монгол Базалт” ХК нь ТУЗ-ийн 2019 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 4 тоот тогтоолоор 2018 оны цэвэр ашгийн 86% буюу нэгж хувьцаанд 3 төгрөг 30 мөнгө тараасныг 2019 оны 06 дугаар сарын 24-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршууллаа.

**“ЭРДЭНЭС МОНГОЛ” ХХК: 2019-2023 ОНЫ ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ БАТАЛЛАА. (bloombergtv.mn)**

“Эрдэнэс монгол” ХХК 2019-2023 оны дунд хугацааны стратеги баталж, үнэт металл, алт цэвэршүүлэх үйлдвэрийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, нүүрсний давхаргын метан хийн хайгуул, олборлох үйлдвэр, ган төмөрлөгийн цогцолбор үйлдвэр барих зэрэг төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгааг мэдээллээ. Мөн хувийн хэвшилтэй хамтарч нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлд анхаарах юм байна.

**“ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ” ХК ОЛОН УЛСЫН СТАНДАРТАД НИЙЦСЭН 8.2 КМ АВТОЗАМАШИГЛАЛТАН ДОРУУЛАА. (ikon.mn)**

Төрийн өмчит “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн уурхайгаас Гашуун сухайтын авто замтай холбох 8.2 км хатуу хучилттай авто замын нээлт 2019 оны зургаадугаар сарын 30-нд боллоо.

“Олон улсын стандартад нийцсэн хүнд даацын хатуу хучилттай энэхүү автозамашиглалтад орсноор олонталын ач холбогдолтой. Тухайлбал “Эрдэнэс-Тавантолгой” ХК одоогийн байдлаар 8.3 сая тонн нүүрс экспортлоод байна. Энэ онд нийт 18 сая тонн нүүрс олборлож экспортлох төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. Тэгэхээр энэ зам экспортын хэмжээг нэмэгдүүлэх, улсын төсөвт төвлөрүүлэх татварын хэмжээг нэмэгдүүлэх гээд эдийн засгийн хувьд чухал ач холбогдолтой. Мөн жолооч нарын аюулгүй, ая тухтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг бууруулахад эерэг нөдөө үзүүлнэ.

“Эрдэнэс-Тавантолгой” ХК хоёр жилийн өмнө Өмнөговь аймагтай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. Гэрээнд тусгагдсан бүтээн байгуулалтын ажлууд хийгдээд явж байгаагийн нэг нь өнөөдөр ашиглалтад оруулж байгаа 8.2 км авто замын ажил юм. Энэ зам ашиглалтад орсноор сумын байгаль орчин, тоосжилт, иргэдийн эрүүл ахуйгаас гадна жолооч нарын аюулгүй байдалд ч эерэгээр нөлөөлнө. Мөн Монгол Улсын нүүрсний экспортыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой. “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн ашиг, улсад төвлөрүүлж буй татвар бол их бүтээн байгуулалтын эхлэл нь болж байгаа юм”

**ЭНЭТХЭГ УЛСЫН ЭЛЧИН САЙД АРИЛЖАА НЭЭЖ ЦАН ЦОХИЛОО. (MSE.MN)**

Бүгд Найрамдах Энэтхэг Улсаас Монгол Улсад суугаа элчин сайд Ноён М.П Сингх Монголын хөрөнгийн биржид зочилж, 6,004 дэх удаагийн үнэт цаасны арилжааг нээж цан цохилоо.

Энэхүү ёслолын арга хэмжээний дараа болсон хөрөнгийн зах зээлийн талаарх танилцуулга уулзалтын үеэр Монголын хөрөнгийн зах зээлд Энэтхэг улсын хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх, Энэтхэг улсын зүгээс хэрэгжүүлж буй төслүүдийг хөрөнгийн зах зээлийн оролцоотойгоор хэрэгжүүлэх боломж гэх зэрэг олон асуудлаар санал бодлоо солилцож, цаашид идэвхтэй хамтран ажиллах сонирхолтой байгаагаа талууд илэрхийллээ.



**О.Уранбайгаль**

Харилцагчийн албаны менежер  
И-мэйл: baigal@bdsec.mn

БиДиСек төв оффис

Залуучуудын өргөн чөлөө 27-1  
8-р хороо, Сүхбаатар дүүрэг  
Улаанбаатар, Монгол улс  
Утас: 976-7555-1919  
Факс: 976-11-321763

**Д.Шүрэнцэцэг**

Харилцагчийн алба, мэргэжилтэн  
И-мэйл: shurentsetsegd@bdsec.mn

БиДиСек төв оффис

Залуучуудын өргөн чөлөө 27-1  
8-р хороо, Сүхбаатар дүүрэг  
Улаанбаатар, Монгол улс  
Утас: 976-7555-1919  
Факс: 976-11-321763

**Б.Онон**

Харилцагчийн алба, мэргэжилтэн  
И-мэйл: Onon.b@bdsec.mn

БиДиСек төв оффис

Залуучуудын өргөн чөлөө 27-1  
8-р хороо, Сүхбаатар дүүрэг  
Улаанбаатар, Монгол улс  
Утас: 976-7555-1919  
Факс: 976-11-321763

Энэхүү арилжааны мэдээ нь зөвхөн арилжааны болон санхүүгийн мэдээлэл өгөх зорилготой бөгөөд аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Энэхүү мэдээнд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “БиДиСек ҮЦК” ХК хариуцлага хүлээхгүй болно.